# “ХӨДӨӨГИЙН ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*2009.04.09* *008 оны жилийн эцсийн байдлаар*

| № | Хөтөлбөрийн агуулга | | Гүйцэтгэл | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төслийн нэр | | “Хөдөөгийн ядуурлыг бууруулах ” хөтөлбөр | | |
| 2 | Санхүүжүүлэгч байгууллага | | НҮБ-ын ХААХОУСан | | |
| 3 | Хэрэгжүүлэгч байгууллага | | ХХААХҮЯ | | |
| 4 | Хамрах хүрээ | | Архангай, Булган, Хөвсгөл, Хэнтий аймгуудын бүх сумд хүн амын 90-95% буюу 80000 өрх | | |
| 5 | Хөтөлбөр хэрэгжих хугацаа | | /2003-2010/ 7 жил | | |
| 6 | Хөтөлбөрийн зорилго | | **Зорилго:** Хөдөөгийн малчид, тариаланчид, хөдөөгийн эмзэг бүлгийн иргэдийн үйлдвэрлэл эрхлэх, бүтээх чадавхийг дээшлүүлэхийн зэрэгцээ боловсрол, эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нь бүрдүүлж өгөх замаар, тэдний орлогыг нэмэгдүүлэх, ядуурлаас гаргах явдал юм. | | |
| 7 | Хөтөлбөрийн зорилтууд | | Малчид, тариаланчид болон зорилтод бүлгийн иргэдийн үйлдвэрлэлийн чадавхийг тогтвортойгоор нэмэгдүүлэх, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгэм, эдийн засгийн нөөц баялгаас хүртэх хүртээмжийг сайжруулна. | | |
| 8 | Төслийн үр шим хүртэгчид | | **2009 оны эцсийн байдлаар**: 4 аймгийн 80000 өрхөд хөтөлбөрийн үйл ажиллагааг хүргэнэ гэсэн зорилт тавьсан бөгөөд тайлант үеийн байдлаар: 65740 өрх хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаас ямар нэг хэлбэрээр шим хүртсэн нь тавьсан зорилтын 82,0% болж байна. | | |
| 9 | Зардал /2003-2010/ | Төсөв /нийт зардал/ | 19081,0 мян. ам.доллар | | |
| | | Тайлант онд зардлууд | Төсөв /мян₮/ | гүйцэтгэл/мян.₮/ | хувь |
| | 1.Дэмжих болон хэрэгжүүлэх нэгжийн зардал | | 718,752.76 | 595,399.73 | 82,8 |
| | 2.Бэлчээрийн менежмент | | 1,479,840.00 | 465,105.80 | 31,4 |
| | 3.Мал үржил | | 340,418.80 | 289,851.60 | 85,2 |
| | 4.Эмэгтэйчүүдийн хөгжил | | 198,120.00 | 193,048.40 | 97,4 |
| | 5.ОББҮА-ны хөрөнгө оруулалт | | 257,136.00 | 156,497.90 | 60,9 |
| | 6. Боловсрол | | 176,220.00 | 164,430.20 | 93,3 |
| | 7.Эрүүл мэнд | | 95,000.00 | 93,430.90 | 82,9 |
| | 8.ХААҮШУОНТөв | | 187,832.00 | 140,733.30 | 74,9 |
| | **Нийт дүн:** | | **3,453,319.56** | **2,098,497.53** | **60,8** |
| | Санхүүгийн талаар: | | Тус хөтөлбөрийн 2009 онд төлөвлөсөн хөрөнгийн 60,8% нь зарцуулагдсан боловч төлөвлөсөн ажлууд 100%-тай хийгдсэн нь дараахь шалтгаантай болно. Үүнд:<br>1.ХААХОУСангийн зөвшөөрлийн дагуу ган зуд болсон үед зарцуулагддаг 800,0 сая.₮ 2009 онд зарцуулагдаагүй.<br>2.Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих ажлын санхүүжилт эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс 75,0 сая.₮ зарцуулагдаагүй.<br>3.гадаад болон дотоод зөвлөхийн зардал 30,0сая.₮ хэмнэгдсэн. | | |

<table>
<tr><td></td><td colspan="2"></td><td colspan="6">4.Тендер зарласны дагуу тухайн ажил, үйлчилгээг хийх гүйцэтгэгчийн өгсөн саналаар 117,1 сая.₮ хэмнэгдсэн.<br>5.Мониторинг үнэлгээ, аудит, санхүүжүүлэгч байгууллагын, орчуулагчийн, ХХН-үүдийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 95.0 сая.₮-ийг тус тус хэмнэсэн нь нийт 1117,1 сая.₮ болж байна. Өөрөөр хэлбэл: Дээрх хэмнэлт болон шийдвэр гараагүйн улмаас зарцуулагдаагүй хөрөнгийг оруулан тооцвол хөтөлбөрийн төлөвлөсөн хөрөнгийн зарцуулалт 93,5% болох ба үлдэх 6,5%-ийн хөрөнгө нь сургалт болон бусад ажлыг хийх хөрөнгөнөөс хэмнэгдсэн байна.<br>Хөтөлбөр эхэлснээс хойш нийт 50 удаагийн татан авалтаар 14,154,647.34 ам.$ буюу 17,066.44 сая.₮ -ийг ХААХОУСангаас, Монгол Улсын төсөв болон аймгуудын төсвөөс 1,562.8 сая₮ , НӨАТ-ын хөнгөлөлтөөс 831.6 сая.₮-ийг тус тус авч нийт 19,460.84 сая₮ зарцуулснаар нийт төсвийн 87,6%-ийг, ХААХОУС-ийн зээлийн хөрөнгийн 84,2%-ийг тус тус зарцуулсан тооцоо гарч байна. Нийт хөрөнгийн зарцуулалтын хувь ХААХОУС-аас авсан хөрөнгийн зарцуулалтаас их байгаа нь ханштийн зөрүү буюу долларын үнийн өсөлтөөс хамаарч байна.</td></tr>
<tr><td rowspan="2">9</td><td rowspan="2">Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ</td><td>Биелэлт% 80.1%</td><td>Дүн</td><td>I</td><td>II</td><td>III</td><td>IY</td><td>Y</td></tr>
<tr><td>II шатны зорилт,</td><td>5</td><td>80,5%</td><td>80.0%</td><td>82.7%</td><td>72.0%</td><td>85.3%</td></tr>
<tr><td>10</td><td colspan="2">Хөтөлбөрийн хэрэгжилт</td><td colspan="6">2009 оны хэрэгжилт- 80.1%</td></tr>
<tr><td></td><td colspan="8">1.Мал аж ахуй байгалийн нөөцийн менежмент зорилтын хүрээнд:<br>Зорилт1-ийн дүн: (70+85+95+75+83+80)/6=80,5%</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Үр дүн 1.1: Бэлчээрийн менежмент</td><td colspan="6">БМХХ, Малчны бүлгүүд байгуулах ажлын хүрээнд: 4 аймгийн 79 сум, 351 багт нийт 416 БМХХ-дыг байгуулж, 54,3% буюу 226 БМХХ-ны үйл ажиллагаа тогтвортой явагдаж байна. 32 БМХХ нь ТББ болж, тамга тэмдгээ авч, хуулийн этгээд болжээ. Бэлчээрийг хувиартай ашиглах, байгалийн эрсдлийг даван туулах, амьжиргаагаа сайжруулахад хамтран ажиллах зорилт бүхий МБ-ийг өөрсдийнх нь хүсэл сонирхлоор байгуулах үйл явцыг өрнүүлж уулзалт, сургалтууд зохион байгуулах, бодит дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээ авсны үр дүнд 4 аймгийн хэмжээнд нийт 1500 гаруй МБ байгуулагдан нийт бүлгийн 60% буюу 870 МБ тогтвортой ажиллаж байна. МБ-үүд хөтөлбөрийн үр шимийг:<br>• МАА, газар тариалан, орлого нэмэгдүүлэх чиглэлээр талбайн болон танхимын сургалтад хамрагдах<br>• Өөр хоорондоо туршлага солилцох уулзалтад оролцох<br>• Бага оврын тоног төхөөрөмжийн дэмжлэг авах<br>• Төмс, хүнсний ногоо тариалах үр, бусад шаардлагатай материал, тоног төхөөрөмжөөр хангагдах<br>• Жижиг зээлд хамрагдах зэрэг хэлбэрээр хүртсэн.</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | БМХХ болон ТББ-ын санаачилгаар: тухайлбал, Архангай аймагт 385 га-д чацаргана, царгас тариалж,бэлчээрийг цөлжилтөөс сэргийлэх, 2067 га газрыг хашиж хамгаалжээ.<br>Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум бэлчээрийн бодлогоо тодорхойлж ажилласны үр дүнд нийт малчин өрхийн 80% нь өвөлжөө, хаваржааныхаа нутгийг чөлөөлж, өвөлжөөнд буух хугацааг 20-30 хоногоор уртасгаж, өвлийн бэлчээрээ нөөцөлдөг болсон. Хөтөлбөр эхэлснээс хойш нийт 64 ТББ байгуулах атал 50% нь байгуулагдсан байна. ТББ-дын үйл ажиллагаа жигд бус байгаа нь мэргэжил арга зүйн хувьд бие даан ажиллах чадвар сул, төсөв санхүүжилт байхгүйн улмаас үйл ажиллагааг хэвийн явуулах боломжоор хязгаарлагдмал байгаа нь ажиглагдлаа.<br>Цаашид: Сумдад ажиллаж буй ТББ-дад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, энэ чиглэлээр улсын хэмжээнд ажиллаж буй ТББ-тай хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх. Бэлчээрийн менежментийн асуудлаао үйл ажиллгаа явуулж буй бусад ОУ-ын байгууллагуудтай холбож өгөх, ТББ-дын удирдлагуудын чадавхийг дээшлүүлэх, сургагч багш бэлтгэх замаар малчдад бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлийн сургалтуудыг эрчимтэй явуулах шаардлагатай байна.<br>**Хэрэгжилт-70.0 %** |
| | **Үр дүн**: Бэлчээрийн усан хангамж буюу худаг засвар | **Бэлчээрийн усан хангамж буюу худаг засварын ажлын хүрээнд:** Хөтөлбөрөөс 540 худгийг засаж, ашиглалтад оруулах зорилт тавьснаас 397 худаг засварлаж, **153** гүний худаг шинээр гаргасан үр дүнтэй байна. Тайлант 2009 онд шинээр 25 худаг гаргаж, 2-оос бусад худгийг улсын комисс хүлээн авч, сумдын ЗДТГ болон эзэмшигч малчин, МБ-дэд хүлээлгэн өгчээ. Мөн бэлчээр, ундны усны хангамжийг сайжруулах үүднээс гар худаг гаргах уралдааныг малчдын дунд зарлаж дүгнэсэн ба үүний үр дүнд 2009 онд-59, нийт 341 гар худаг гаргасан. Хөтөлбөрийн хүрээнд: Бэлчээрийн болон хадлангийн талбайн усан хангамжийг сайжруулах, хүнсний ногоо тариалах зорилгоор бороо, цас, байгалийн ус цуглуулах хөвийг Булган-2, бусад 3 аймаг бүрт 1-ийг барьсан. Ингэснээр 137 өрх 25078 мал услах боломжтой болсон. **Үр дүн**:/тайлант 2009 онд/<br>• 869,2 мян.толгой мал, 1747 өрхийн ундны усны хэрэгцээг хангасан.<br>• 249,3 мян.га бэлчээрийг ашиглах боломжтой болсон.<br>• Засварласан болон гаргасан худгууд цаашид эвдэрч гэмтэхэд хариуцах эзэмшигчидтэй болж, тогтвортой ажиллах боломжоор хангагдсан.<br>• Худгийн тогтвортой байдлыг хангах, хамтын сан бүрдүүлж байгаагийн ачаар малчдын хамтын ажиллагаа сайжирч, худгаас мал услах хуваарь гарган ажиллаж байна.<br>**Хэрэгжилт- 85 %** |

| | | |
|---|---|---|
| | **Үр дүн**: Мал эмнэлгийн үйлчилгээ сайжирна. | 2009 онд энэ чиглэлээр төсөв хөрөнгө хуваарилагдаагүй бөгөөд өмнөх жилүүдэд 4 аймгийн бүх суманд 1-3 мал эмнэлэгт ямар нэг хэмжээгээр дэмжлэг үзүүлсэн.<br>Хөтөлбөрт хамрагдсан 4 аймгийн төв лабораторийн байрыг засварлаж, тус бүр 25,0 сая₮-ийн өртөг бүхий 124 нэр төрлийн эм, урвалж, орчин үеийн тоног төхөөрөмж олгосны зэрэгцээ автомашин, компьютер, принтер зэрэг оффисийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлжээ. Лабораторийн тоног төхөөрөмж авсан хувийн мал эмнэлгүүд үнийн дүнгээс шалтгаалан 7-10%, эмийн эргэлтийн сан бүрдүүлэх үүднээс зээлээр эм олгон мөн тодорхой хувийг эргүүлэн төлүүлж аймаг бүрийн эргэлтийн санд төвлөрүүлж байна. Архангай аймаг: Лабораторийн тоног төхөөрөмжийн эргэн төлөлт-98,6%, малын эмийн эргэлт-91,1%, Булган: Лабораторийн тоног төхөөрөмж-100%, эмийн сангийн тусламжийг буцалтгүй хэлбэрээр олгосон, Хөвсгөл: Лабораторийн төхөөрөмж-79,0%, эмийн сангийн эргэлт-100%, Хэнтий: лабораторийн төхөөрөмж-100%, эмийн эргэлт-96,6%-тай байна.<br>**Хэрэгжилт- 90.0%** |
| | **Үр дүн**: Малын үржил сайжирна. | Малын үржлийн ажлыг сайжруулах чиглэлээр 2009 оны төлөвлөгөөнд: Аймгийн үржлийн төвийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, Үржлийн болон МАА-н бусад үйлчилгээг малчдад хүргэх, Нэн ядуу малчин өрхийг дэмжих буюу сайн чанарын малаар малжуулах чиглэлийг тусгаж ажиллажээ.Аймгуудын ХХН, цөм сүргийн үржлийн төвүүд хматран хэрэгжүүлэх гэрээ байгуулж ажилласан байна.Үүнд:<br>- 4 аймгийн ЦСҮТ-ийг бэхжүүлэхэд 31,0 сая.төг,<br>-2008 онд Архангайгаас бусад 3 аймгийн 15 суманд 16 зохиомол хээлтүүлгийн пункт ажиллуулж 406 үнээг сайн үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлж 2009 онд 274 төл хүлээн авчээ.<br>-4 аймгийн хэмжээнд нийт 306 ядуу өрхөд сайн үүлдрийн мал олгосон.<br>Хөвсгөл амигийн ЦСҮТ-д 6,0 сая₮ -өөр Дархад омгийн 150 эм хонь худалдан авч өгсөн.<br>-Архангай ЦСҮТ-ийг бэхжүүлэхэд нийт 27,0 сая₮-ийн шилмэл мал авч дэмжлэг өгчээ.<br>2008 онд 406 үнээнд зохиомол хээлтүүлэг хийснээр 67,5% буюу 274 тугал хүлээж авчээ. 2009 онд 306 ядуу өрхөд тугалтай үнээ, хургатай хонь буюу нийт 126,5 сая₮ бүхий 1096 мал олгож дэмжлэг үзүүлсэн.<br>**Хэрэгжилт- 75%** |
| | **Үр дүн:** ХААНТөвийн үйлчилгээг бий болгож дэмжинэ. | Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш 4 аймгийн төв, 79сум, 201 багт ХААНТ, сургалтын танхимыг байгуулж, сургалтын байртай болгосон. Бүх төвүүдийг сургалтын болон оффисын тоног төхөөрөмжөөр хангасан. Аймгийн ХААНТ-д автомашин, сумдын ажилтнуудад мотоцикл олгосон. 2009 онд аймгуудын ХААНТ төрөл бүрийн сургалт явуулснаас нийт 2421 хүн хамрагдаж, 70 төрөл чиглэлээр 12970ш гарын |

| | | |
|---|---|---|
| | | авлага, зөвлөмж хэвлүүлж, иргэдэд тараасан. 4 аймгийн экстейншний ажилтны нэгдсэн уулзалт зөвлөгөөнийг Хөвсгөл аймагт зохион байгуулжээ. **Гарсан үр дүн:**<br>• 4 аймаг, сумын түвшинд ХААНТ-ийг байгуулснаар хөдөөгийн иргэд малчдад үйлдвэрлэл эрхлэх арга зүй, технологи, бүтээгдэхүүний борлуулалт зэрэг асуудлуудаар зөвлөгөө өгч, төрөл бүрийн сургалтыг тогтмол явуулах нөхцөл бүрдлээ.<br>• ХААНТ-ын мэргэжилтнүүдийг систэмтэйгээр сургалтад хамруулж, сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх мэргэшсэн ажилтныг бэлтгэхэд анхаарч, малчдыг мэдээлэл, чанартай үйлчилгээгээр хангах боломжийг бүрдүүлсэн.<br>• Аймгийн ХААНТ-үүд аймгийн телевиз, радиогоор төмс, хүнсний ногоо тариалах, үр бэлтгэх, хүнсний ногооны өвчин, хортонтой тэмцэх, гахай, шувууны аж ахуйг эрхлэх талаар төрөл бүрийн хичээл, үзүүлэх сургалтуудыг зааж, гарын авлага материал тараасан нь иргэдийн талархалыг хүлээсэн үйл ажиллагаа болсон.<br>• Малчид, хөдөөгийн жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаанд оролцож, бүтээгдэхүүнээ сурталчлах сонирхол эрс нэмэгдэж, бүтээгдэхүүний сав, баглаа, боодлын чанар, үзэмжид ахиц гарч сайжирсан.<br>**Хэрэгжилт 83.0 %** |
| | Үр дүн:Зудын аюулгүй сан | **"Аюулгүйн сангийн Зарцуулалт":** Тус сангийн хөрөнгө жил бүрийн төсөвт тусгагддаг боловч ашиглах нөхцөл бүрдээгүй үүднээс 2008 оны эцэс гэхэд тус хөрөнгийн 30% буюу 258,7 сая.₮ ашигласан. Үлдэх хөрөнгийг ХУҮХорооны баталсан журмын дагуу 1 суманд 5-8 сая.төг –ийн сан бүрдүүлж малчдад зөвхөн өвлийн бэлтгэлээ хангахад, банкны хүүгээс доогуур хүүтэй олгохоор тусгасан. Аймаг бүрээс 1 суманд 5,0 сая.төг буюу нийт 20,0 сая.төг-ийн зээл олгосноос 18,0 сая.төг зарцуулагдаад байна. Сарын 0,5-1,0%-ийн хүүтэй 1 жилээр олгожээ. Зээлдэгчид өвс тэжээл, хадлан бэлтгэх, хашаа барих, царгас, чацаргана тариалж үр авахад зориулж зээл аван зарцуулалт харьцангуй сайн байна. 2009-2010 онд өвөлжилт улсын хэмжээнд хүндэрсний улмаас энэхүү сангийн тодорхой хувь буюу 400 сая.төг-өөр тэжээл худалдан авч малчдад олгох шийдвэрийг санхүүжүүлэгч байгууллага, ХХААХҮЯ болон хөтөлбөрийг удирдах үндэсний хороогоор хэлэлцэж тогтжээ.<br>**Хэрэгжилт 80.0 %** |
| | **2.Нийгмийн хөгжил** зорилтын хүрээнд:<br>Зорилт2-ын дүн (70+85+85)/3=**80,0%** | |
| | Үр дүн. 2.1. Эмэгтэйчүүдийн хөгжил | **Үр дүн 2.1.-ийн хүрээнд:** Хөдөөгийн эмэгтэйчүүдийн ОНБ-ын бие даан үйл ажиллагаа явуулах чадавхийг бэхжүүлэх үүднээс 4 аймгийн ЭЗ-ийг автомашин, компьютер принтер зэрэг оффисын тоног |

| | | |
|---|---|---|
| | | төхөөрөмжийг нийлүүлсэн. Хэнтий, Булган аймгуудын ЭЗ-ийг байртай болгосон.<br>-Орлого бий болгох<br>-Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд<br>-Гэр бүл төлөвлөлт<br>-Нөхөн үржихүйн эрүүл мэнд чиглэлээр 28.0 мянга гаруй эмэгтэйчүүдэд сургалт хийсэн. 2009 онд 2937 хүн хамрагджээ. Сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг байна. Хөдөөгийн ядуу, өрх толгойлсон эмэгтэйчүүд болон бүлгүүдэд бичил бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэхэд нь зориулж 2 хүртэл хувийн хүүтэй, 24 сар хүртэл хугацаатай барьцаагүй зээл олгох гэрээг МЭХ, Хас банк, ХДН-ийн хооронд байгуулсан. Энэхүү олгосон 120,0 сая.₮-ийг бүрэн зарцуулсан бөгөөд зээл 2,3 дахь шатны зээл олгогдож байна.Бүлгийн болон ганцаарчилсан нийт зээл авсан эмэгтэйчүүд давхардсан тоогоор 160-д хүрчээ. Мөн ХААН банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч ажил удаашралтай явж 2010 оны 1 сарын байдлаар 18,5 сая.төг зээл олгогджээ. Хөтөлбөрийн хүрээнд оруулсан **хөрөнгө оруулалтын үр дүнд:**<br>• Орон нутгийн ТББ-ын чадавхи бэхжин, тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжтой болсон.<br>• Сургалтад хамрагдаж, мэдээлэл авснаар гэр бүл, өрхийн төсвөө сайтар төлөвлөн, эрүүл аж төрөх арга замыг амьдралдаа хэвшүүлж байна.<br>• Бичил санхүүгийн үйл ажиллагааг хөдөөгийн ядуу эмэгтэйчүүдэд барьцаа шаардахгүйгээр олгосноор эмэгтэйчүүд бичил бизнес эрхлэх, бусадтай хөдөлмөрөө хоршин, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой болсон.<br>**Хэрэгжилт- 70.0%** |
| | Үр дүн. Боловсрол | 2009 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын ХэрлэнбаянУлаанд 40 ортой сургуулийн дотуур байрыг шинээр барьж ашиглалтад оруулжээ. Хэрлэнбаян-Улаан нь зүүн бүс нутгийн отрын бүс нутагт тооцогддог бөгөөд Сүхбаатар, Хэнтий зэрэг зүүн аймагт зуншлага, өвөлжилт жил дараалан хүндэрч, малаа даган ирж өвөлжижи буй малчин өрхийн хүүхдүүдэд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх үүднээс уг арга хэмжжэг авсан нв зөв шийдэл болжээ. 644 насанд хүрсэн бичиг үсэггүй хүмүүс сургалтад хамруулж, ХХН, аймгийн БСГ-ын даргын гарын үсэг бүхий гэрчилгээ олгосон. Хөтөлбөрөөс “Хөдөлгөөнт цэцэрлэг” хэмээх шинэлэг бөгөөд малчдын хамгийн их талархал хүлээж буй үйл ажиллагааг санхүүжүүлж ирсэн. 4 аймгийн бүх сум, багт ажиллуулж, давхардсан тоогоор 29785 хүүхдийг хамруулан, СӨБ олгосон. 2009 онд 5659 ххүхэд хамрагдсан. <u>**Үр дүн:**</u><br>-Хөдөөгийн алслагдсан малчдын хүүхдэд СӨБ олгох нүүдлийн цэцэрлэг, сургууль завсардсан хүүхдэд нөхөн боловсрол олгох албан бус сургалт, насанд хүрэгчдэд зориулсан бичиг үсгийн сургалт явуулахын зэрэгцээ сургуулийн багш нарыг мэргэшүүлэх |

| | | |
|---|---|---|
| | | сургалтад хамруулж, чадавхийг нь бэхжүүлснээр хөдөө орон нутагт байгаа хүүхдүүд чанартай боловсролоор хангагдах боломжтой болсон.<br>-Тайлант 2009 онд 3 сургуулийг интернетэд холбосноор 77 багш, 1102 сурагчид сүүлийн үеийн мэдээллийг авах боломжтой болсон. Нийт 23 сумын сургууль интенетэд холбогджээ.<br>-Хөдөлгөөнт цэцэрлэгийг багт ажиллуусны үр дүнд Хэнтий аймагт СӨБ –ын хамрагдалт-40.1%, Булган-21.6%, Архангай-49%, Хөвсгөл-23.2%-иар өссөн үзүүлэлт гарчээ.<br>-Архангай, Булган аймгуудад нүүдлийн цэцэрлэгийг түшиглэн хөтөлбөрийн болон цаг үеийн мэдээллийг алслагдсан багийн малчдад хүргэх мэдээллийн төв, нүүдлийн номын сан зэргийг ажиллуулсан.<br>**Хэрэгжилт- 85.0%** |
| | Үр дүн: Эрүүл мэнд | **2009 онд** хийгдсэн хамгийн томоохон ажил нь аймаг бүрт нэг сумын төвийн эмнэлгүүдийн усны эх үүсвэрийг шийдвэрлэх явдал байсан. Үүний дагуу Архангай аймгийн Төвшрүүлэх, Булган аймгийн Гурванбулаг, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, хэнтий аймгийн Баянмөнх сумдын эмнэлгүүдэд худаг шинээр гаргаж эмнэлэгтэй нь холболт хийснээс гадна Гурванбулаг суманд өвчтөнүүдийн ундны усанд цэвэршүүлэх шүүгчийг суурилуулжээ.<br>Мөн Архангай аймагт нярайн эндэгдэл улсын дунджаас харьцангуй өндөр байдаг бөгөөд нярайн зарим онц шаардлагатай тоног төхөөрөмж байхгүй тул, аймгийн Засаг дарга, ЭМГ-аас хүсэлт тавьсны дагуу ХААХОУСангаас зөвшөөрөл олгож 43,0 сая.₮-ийг тусгаж, тендер зарласан. Тус аймгийн ЭМГ-ын захиалсан ххүүхдийн зохиомол амьсгалын аппарат, нярайн инкубатор зэрэг үндсэн 3 төрлийн тоног төхөөрөмжийг нийлүүлэхээс гадна, нээлттэй худалдан авалтаас хэмнэгдсэн хөрөнгөөр хөлдөөсөн сийвэн үйлдвэрлэх гүн хөлдөөгчтэй центрифуг, сэхээний кардиомониторийг аймгийн хүсэлтээр нэмж нийлүүлснээр аймгийн төвийн эмнэлэг орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.<br>**Хэрэгжилт 85.0 %** |
| | **3.Эдийн засгийн бусад үйл ажиллагаа**<br>Зорилт 3-ын хэрэгжилт - (83.0+82.5)/2=**82.7%** | |
| | Үр дүн: Орлого бий болгох үйл ажиллагаа нэмэгдэнэ. | Энэ ажлын хүрээнд: 842 тоног төхөөрөмжийг олгосноос 70 орчим хувь нь ядуу, нэн ядуу, 28 хувь нь дундаж, 2% нь боломжийн өрхүүдэд ашиглагдаж байна. ХААОУС-аас өгсөн зөвлөмж, ХУҮХ-оос гарсан шийдвэрийн дагуу:<br>• 800.0 мянган төгрөгөөс доош өртөг бүхий тоног төхөөрөмжийг буцалтгүй тусламж болгон эзэмшигчид нь хүлээлгэн өгөх,<br>• 0.8-1.5 сая.төг хүртэл өртөгтэй тоног төхөөрөмжийн 7%,<br>• 1.5 сая.төг-өөс дээш өртөгтэй тоног төхөөрөмжийн 10%-ийг эргүүлэн төлүүлэхээр шийдвэрлэсний дагуу эргэн төлөлт хийгдэж байна.<br>**<u>Эргэн төлөлтийг харахад:</u>** |

| | | |
|---|---|---|
| | | - **Архангай-** 7,0%-ийн эргэн төлөлт-46%, 10%-ийнх-64%, 100% эргэн төлөлт-40% буюу энэ арга хэмжээг биелүүлэх талаар **"Маш хангалтгүй"** ажиллаж байна.<br>- **Булган-** 7%, 10%-ийн эргэн төлөлт-100 хувь, 100% эргэн төлөлт-82,3% буюу хамгийн сайн ажиллаж байна.<br>- **Хөвсгөл-** 7%-ийн эргэн төлөлт-94,7%, 10%-ийнх-81,0%, 100% эргэн төлөлт-64,0%<br>- **Хэнтий-** 7%-ийн эргэн төлөлт-100%, 10%-ийнх-96,0%, 100% эргэн төлөлт-76,6% тус тус төлөлттэй байна.<br>**Дээрх үйл ажиллагааны үр дүнд:**<br>- 2500 гаруй байнгын ажлын байр бий болгож, 1000 гаруй жижиг бизнес, үйлдвэрлэлийг эхлүүлэх буюу өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлсэн байна. Зөвхөн 2009 онд 251 ажлын байр нэмэгджээ.<br>4 аймгийн бараг сум бүрт үсчин, гутал засвар, оёдлын цехийг хөтөлбөрийн дэмжлэгтэй байгуулж өгсөн бөгөөд ихэнх нь тогтвор суурьшилтай ажиллаж орлогоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ иргэдийн өдөр тутмын хэрэгцээг хангаж ажиллаж байна.Тухайлбал: Үр шим хүртэгч хэнтий аймгийн Баянхутаг сумын оёдолчин Д.Оюунцэцэг нь сумын тэргүүний үйлдвэрлэгч эмэгтэйгээр шалгарч, үйл ажиллагаа нь тогтмолжижи өрхийн орлогоо нэмэгдүүлж байна.<br>**Хэрэгжилт- 83.0%** |
| | Үр дүн: Хүнсний ногоо тариалалт | Хүнсний аюулгүй байдлыг хангах, өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор хөтөлбөрөөс нийт давхардсан тоогоор 31.0 мянган айл өрх үрийн дэмжлэг авсан бөгөөд тайлант 2009 онд 1970 өрх дэмжлэг авчээ. Мөн стандартын 92 ш/6х10/ хүлэмж олгож дэмжсэн ба эдгээрээс 4242 орчим нь арилжааны үйлдвэрлэл явуулж байна. Өссөн дүнгээр 31000 өрхөд төмс, хүнсний ногоо тариалахад үрийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд үүний 16740 буюу 54% нь бие даан ногоо тариалах чадвартай болжээ. Үүний үр дүнд:<br>• Хөдөөгийн иргэд, малчдын дунд хүнсний ногоо тариалах сонирхол нэмэгдэж, технологийн мэдлэг дээшилж, сүүлийн жилүүдэд бие даан тариалалт эрхэлж буй өрхийн тоо өссөн.<br>• Орон нутгийн иргэд эрүүл, чанартай хүнсний бүтээгдэхүүнээр хангагдаж, хүнсний аюулгүй байдал сайжирсан.<br>• Зоорь барих дэмжлэг үзүүлснээр хураан авсан ургацаа чанарыг нь алдагдуулахгүй хадгалах, тухайн орон нутгийн хэрэгцээг урт хугацаанд хангаж, орлого ашгаа нэмэгдүүлээд зогсохгүй төмс, хүнсний ногооны үрээ хадгалж, тариалалтыг тогтвортой үргэлжлүүлэн авч явах боломжтой болсон.<br>Ногоочид урьд өмнөх жилүүдийн ургацын үзэсгэлэн худалдаанаас туршлагажиж, сав баглаа боодол, бүтээгдэхүүний хяаг, шошгоо сайжруулж байгаа нь илт ажиглагдаж байна.<br>**Хэрэгжилт 82.5%** |

| | | |
|---|---|---|
| | **4. Хөдөөгийн санхүүгийн үйлчилгээ**<br>Зорилт 4-ын хэрэгжилт – 72.0**%** | |
| | Үр дүн: Хөдөөд ядуурал, хүйсийн мэдрэмж бүхий санхүүгийн үйлчилгээг хүргэнэ. | Хөдөөд санхүүгийн үйлчилгээ бүрэлдэхүүн хэсгийг Хас банк 4 аймгийн 50 орчим суманд хүргэж байна. Хөтөлбөрийн хүрээнд тус банк 31390 зээлдэгчид 26.3 тэрбум төг-ийн зээл олгосон. 2009 оны байдлаар 1248 зээлдэгчид 1,1 тэрбум.төг-ийн зээл олгожээ. 2009 оны 4-р улирлын байдлаар олгосон зээлийн багцыг төрлөөр нь авч үзвэл: Бусад зээл-54%, бичил зээл-31%, хэрэглээний зээл-8%, малчны зээл-7%-ийг тус тус эзэлж байна. Зээлийн багцын чанарыг авч үзэхэд: хэвийн зээл-84%, хугацаа хэтэрсэн зээл 16% байгаа нь өмнөх улиралд 4 аймгийн байдлаар хугацаа хэтэрсэн зээл 19 % байсан бол эрсдэлтэй зээлийн багц 16% болж буурчээ. ХААХОУС-ийн хяналт үнэлгээний ажлын хэсгийн өгсөн зөвлөмжийн дагуу энэхүү дэд бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэгч 2 дахь банкийг сонгон шалгаруулахад Хаан банк шалгарсан. Гэвч үйл ажиллагаа хэт удаашралтай явсан байна.<br>**Хэрэгжилт-72.0%** |
| | **5. Хөтөлбөрийн менежмент** | |
| | Үр дүн: Үр шим хүртэгч, ядуурлын байдал | ХХН-дийн мэдээг нэгтгэн үзэхэд: 63770 өрх хөтөлбөрөөс ямар нэг байдлаар үр шим хүртэж байна гэсэн тооцоо гарсан нь тавьсан зорилтын 80%-д хүрч, эдгээрээс 50% нь шууд үр шим хүртэгсэд байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн нэлээдгүй хэсгийг эрүүл мэнд, боловсрол, мал эмнэлэг, үржил зэрэг үйл ажиллагаанд зарцуулж зорилтод бүлэгт шууд чиглэгдсэн ажлууд нь нийт үйл ажиллагааны багахан хувийг эзэлдгээс шалтгаалан ядуу иргэдийн хамрагдалт тийм ч хангалттай байж чадахгүй байна. Хэрэгжүүлэх нэгжүүдийн гаргасан тооцоогоор 4 аймгийн нийт ядуу өрхийн 70 орчим хувийг хөтөлбөрөөс ямар нэг байдлаар үр шим хүртсэн тооцоо гарчээ. Энэ нь хэдийгээр давхардсан тоогоор гарч байгаа боловч хөтөлбөр эхлэх үед ядуу өрхийн тоо дээрхээс бараг 2 дахин өндөр байсан гэж үзвэл үр шим хүртсэн ядуу өрхийн тоо бодитой гэж хэлж болох юм. Төмс хүнсний ногоо тариалах, тоног төхөөрөмжийн дэмжлэг, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах, бүлгийн зээлд хамрагдах, Аюулгүйн сангаас өвс тэжээлийн тусламж олгох, сайн үүлдрийн мал олгох, засварласан худгийг хариуцуулан ажиллуулах, бичиг үсгийн болон сургууль завсардалтын сургалт зэрэг үйл ажиллагаанаас ядуу өрхүүд шууд үр шим хүртэж байна. ҮСГ-аас гаргасан хөдөөгийн ядуурлын дундаж түвшинг хөтөлбөрийн аймгуудын дундажтай харьцуулбал:<br>-Хөдөөгийн дундаж- 46,6%<br>-Хөтөлбөрийн аймгуудын дундаж-31,5% байна. Гэвч 2008 оны хагас жилээс хойш улс орныг хамарсан санхүү, эдийн засгийн хямрал, 2009-2010 оны зуд зэрэг нь хөдөөгийн хүн амын амьжиргаанд хүчтэй нөлөөлж байгааг хөтөлбөр дуусах шатанд харгалзан |

| | | |
|---|---|---|
| | | үзэх нөхцөл болж байна. 2009 онд 17502 хүн сургалтад хамрагдсан бөгөөд нийт өссөн дүнгээр 105985 хүн хамрагджээ. Мөн мэдээлэл харилцааны чиглэлээр хөтөлбөрийн ерөнхий үйл ажиллагааг харуулсан 20-25 минутын баримтат кино, үр дүнтэй хэрэгжижи буй үй ажиллагааны талаар 10-15 минутын богино хэмжээний 4-ТВ нэвтрүүлэг, ХХН-дийн бэлтгэсэн баримтат кино, нэвтрүүлэг болон өссөн дүнгээр орон нутгийн болон үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслээр 270 гаруй удаа мэдээлэл сурталчилгаа явуулж, 20,0 мянга гаруй ш гарын авлага, тараах материалыг хөдөөгийн иргэдэд бэлтгэжээ.<br>**Хэрэгжилт 85.3 %** |

| | Зорилтуудын биелэлт /шалгуур үзүүлэлтээр/ | зорилт | биелэлт | % |
|---|---|---|---|---|
| 11 | **1.Мал аж ахуй байгалийн нөөцийн менежмент** | | | |
| | **1.1.Бэлчээрийн менежмент: 111,8%** | | | |
| | 79 сум, 271 багийн БМХХ байгуулна. | 350 | 414 | 118.2% |
| | Байгалийн нөөцийн төлөвлөгөө зураглалыг 79 сум, 271 багийн түвшинд хийнэ. | 76 | 79 | 104.0% |
| | Малчдыг бэлчээрийн менежментийн сургалтад хамруулна. | 17000 | 26279 | 154,5% |
| | Худаг засна. | 540 | 538 | 99.6% |
| | Худаг эзэмшигчийг сургана. | 540 | 588 | 108.8% |
| | Хортон мэрэгчийн судалгаа хийж, үзүүлэх сургалт зохион байгуулна. | 12 | 12 | 100.0% |
| | Малчдыг өвлийн бэлтгэл хангах сургалт, үзүүлэх сургалтад хамруулна. | 17000 | 12621 | 74,2% |
| | Малчдын бүлэг байгуулна. | 271 | 1670 | 6,1 дахин их |
| | **1.2.Мал аж ахуйг дэмжих үйлчилгээ** | | | |
| | Сонгогдсон аймаг, сумдын лабораторийг засаж тоног төхөөрөмжөөр хангана. | 4 аймаг, 79 сум | 4 аймаг, 79 сум | 100.0% |
| | Аймгуудын мал эмнэлгийн холбоог бэхжүүлнэ. | 4 | 4 | 100.0% |
| | Үржлийн техникчдийг сургана. | 60 | 22 | 36,7% |
| | Сумдад аюулгүйн сан байгуулна. | 79 | 4 | 5,1% |
| | **1,3.ХААНТөвийг бэхжүүлэх** | | | |
| | Сонгогдсон аймгуудад НТ байгуулж, бэхжүүлнэ. | 4 | 4 | 100.0% |
| | Сумдад НТ-ийг байгуулж, бэхжүүлнэ. | 79 | 79 | 100.0% |
| | Багийн төв буюу сургалтын төвүүдийг засна. | 271 | 203 | 74.9% |
| | Экстейншний ажилтныг сургана. | 83 | 126 | 1,5 дахин их |
| | **2. Эдийн засгийн бусад үйл ажиллагааа-153.9%** | | | |
| | **2.1.Төмс, хүнсний ногоо тариалалт** | | | |
| | Төмс, хүнсний ногооны ажилчдыг сургана. | 79 | 79 | 100.0% |
| | Үзүүлэх сургалт зохион байгуулна. | 464 | 405 | 87,3% |
| | Ногоо тариалагчдыг сургаж, дэмжинэ. | 18000 | 24790 | 137,7% |
| | Сумдад зоорь барина. | 79 | 141 | 178,4% |
| | **2.2.Орлого бий болгох үйл ажиллагаа** | | | |
| | Сумдад ОББҮА-г дэмжих төвийг байгуулж, оффисийн тоног төхөөрөмжөөр хангана. | 79 | 79 | 100,0% |
| | Сумдад оролгын ажилтныг сургана. | 79 | 79 | 100,0% |
| | Айл өрхийг ГТ-ийн бус орлогын үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. | 800 | 2102 | 262,7% |
| | Өрхүүдийг арилжааны чиглэлээр ногоо тарихад нь дэмжлэг үзүүлнэ. /амьжиргааны түвшнээр/ | 1485 | 2028 | 136,5% |
| | Жижиг цех бий болгож дэмжинэ. | 77 | 296 | 384,4% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Иргэдийг орлого бий болгох сургалтад хамруулна. | 12000 | 13360 | 111,1% |
| | **3.0 .Нийгмийн хөгжил-258.5%** | | | |
| | **3.1. эрүүл мэнд** | | | |
| | Сумын эмнэлэг шинээр барьжтоног төхөөрөмжөөр хангана. | 2 | 9 | 450% |
| | Сумдын эмнэлгийг засаж, тоног төхөөрөмжөөр хангана. | 61 | 27 | 44,3% |
| | Багийн эмчийн өрөөг засварлаж тохижуулна. | 49 | 118 | 240,8% |
| | Эмч, эмнэлгийн ажилтныг сургана. | 353 | 2427 | 687,5% |
| | **3.2. Боловсрол** | | | |
| | Сумын сургууль, дотуур байрыг засварлаж тоног төхөөрөмжөөр хангана. | 45 | 65 | 144,4% |
| | Сургууль завсардсан хүүхдийг сургана. | 3900 | 3540 | 90,8% |
| | Сумдад нүүдлийн цэцэрлэг ажиллуулна. | 73 | 79 | 108,2% |
| | Багш нарыг сургана. | 330 | 3096 | 938,1% |
| | **3.3. Эмэгтэйчүүдийн хөгжил-** | | | |
| | Сонгогдсон аймаг, сумын ЭЗ-ийг дэмжинэ. | 4аймаг, 79 сум | 4аймаг, 79 сум | 100,0% |
| | ЭЗ-ийн ажилтныг сургана. | - | 81 | |
| | ЭЗ-ийн сургалтад хамрагдсан хүний тоо | - | 20410 | |
| | **4.Менежмент-91.4%** | | | |
| | 1-дэмжих нэгж, 4 аймагт ХХН-дийг байгуулна. | 4 | 4 | 100,0%. |
| | Ажилтнуудыг сургана. | 38 | 36 | 94,7% |
| | Сумдын Удирдах хороог байгуулна. | 79 | 78 | 98,7% |
| | ХААХОС-ийн зээлийн зарцуулалт 100% байна. | 100,0 | 84,0 | 84.0% |
| | ЗГ-ын хандивын хөрөнгө 100 хийгдэнэ. | 100,0 | 80,0 | 80,0% |

| | |
|---|---|
| дундаж хувь- 153.9% | Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүд хангалттай биелэгдэж, дундаж хувь- 153.9% байгаа нь төлөвлөлтийг дутуу тооцсон, нөөц бололцоог дутуу ашигласан, дайчин, шахуу хийгдээгүйг харуулж байна. |

| | | |
|---|---|---|
| 12 | Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд) | 1.”Эдийн засгийн бусад үйл ажиллагаа” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд: Хөтөлбөрөөс ажилгүй хүмүүсийг мэргэжлийн сургалтад хамруулан сумандаа үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх, төмс хүнсний ногоо тариалах болон зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлснээр ажилгүй хүмүүст орлого бий болгох боломжийг нээж өгсөн. Дэмжлэг авсан хувь хүн орлогоо нэмэгдүүлээд зогсохгүй, тухайн сумын иргэдэд шаардлагатай үйлчилгээг авах, хүнсний аюулгүй байдлыг хангахад чухал арга хэмжээ болсон. 2500 гаруй байнгын ажлын байр бий болгож, 1000 гаруй жижиг бизнес, үйлдвэрлэлийг эхлүүлэх буюу өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлсэн байна. Зөвхөн 2009 онд 251 ажлын байр нэмэгджээ.<br>2. 63770 өрх хөтөлбөрөөс ямар нэг байдлаар үр шим хүртэж байна гэсэн тооцоо гарсан нь тавьсан зорилтын 80%-д хүрч, эдгээрээс 50% нь шууд үр шим хүртэгсэд байна.<br>3. ХААХОУС-аас хийсэн хяналт-үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийн дагуу “Хөдөөд санхүүгийн үйлчилгээг хүргэнэ” гэсэн зорилтын хүрээнд 2 дахь банкаар Хаан банкыг сонгосон боловч тайлант 2009 онд ажил урагшаа ахицтай явсангүй.<br>4.Мөн “Үржил” дэд бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаа болон болзошгүй эрсдлийг даван туулах, чадавхийг бэхжүүлэх сан байгуулах зөвлөмжийн дагуу 4 аймгийн 79 суманд тус бүр 6.0-8.0 сая.төг-ийг байршуулан, “Байгалийн эрсдэлийг даван туулах чадавхийг бэхжүүлэх сан”-г байгуулах чиглэлээр ажиллаж байна.<br>5.”Нийгмийн хөгжил” бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаанууд |

| | | |
|---|---|---|
| | | нь эрүүл мэнд(эмнэлэг), боловсролын үйлчилгээг сайжруулах (тоног төхөөрөмжөөр хангах), эмэгтэйчүүдэд сургалт зохион байгуулах замаар хөдөөгийн ядуурлыг бууруулахад дорвитой хувь нэмэр оруулж байна.<br>6.Санхүүгийн менежмент, зээлийн удирдлага зохицуулалт нь ерөнхийдөө журмын дагуу явагдаж байна. Одоогийн санхүүгийн мэдээллийг давхар хадгалах, дотоод хяналтын механизмыг сайжруулах, бэлэн мөнгөний гүйлгээг багасгах зэрэг үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай.<br>**Хөтөлбөрийн хэрэгжилтэд 80.1% буюу "Хангалттай" гэсэн үнэлгээг өгч байна.** |
| 13 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ | Хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна. |
| 14 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өгөх зөвлөмж | 1.Төрийн байгууллагын зарим ажил үүргийг ТББ-даар гүйцэтгүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх.<br>2.Аюулгүйн сангаас аймгуудад олгосон хөрөнгийн зарцуулалтад,бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах.<br>3.Мал үржлийн ажлыг сайжруулах үүднээс үржлийн техникчдийг сургалтад хамруулж бэлтгэх ажлыг чанаржуулах.<br>4.ХААН банкнаас Эмэгтэйчүүдэд олгох барьцаагүй зээлийн ашиглалтыг сайжруулах. |

Товчилсон үг:
БСТ- Бодлого судлалын төв
БМХХ- Бэлчээрийн Менежментийн Хяналтын Хороо
МБ- Малчдын бүлэг
ТББ- Төрийн бус байгууллага
ЭЗ- Эмэгтэйчүүдийн зөвлөл
СӨБ- Сургуулийн өмнөх боловсрол
ХУҮХ- Хөтөлбөрийг удирдах үндэсний хороо
МЭ- Мал эмнэлэг

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Т.ГАНТУЛГА